



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 02 сарын 01 өдөр

Дугаар 54


Улаанбаатар хот

Г Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч
/брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг
хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4, Хорооны 2013 оны 69 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн тусгай зөвшөөрлийн түр журам”-ын 7.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрхэм сүрэг ХААБ” ХХК-ийн хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.
2. Компанийн оноосон нэрээс “ХААБ” тэмдэглэгээг хасуулж, үйл ажиллагааны чиглэлээ өөрчлөхийг “Эрхэм сүрэг ХААБ” ХХК /Н.Сэлэнгэ/-нд үүрэг болгосугай.
3. “Эрхэм сүрэг ХААБ” ХХК-ийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авч, Санхүүгийн зохицуулах хорооны бүртгэлд холбогдох өөрчлөлт хийж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийт болон харьяалагдах татварын алба, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт ажлын 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН